

**МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО БОЛОН ГИШҮҮН БАНКУУДЫН
ХАМТАРСАН ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ
ДАГАЖ МӨРДӨХ ТУХАЙ САНАМЖ БИЧИГ**

2020 оны 5 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 20/01

Улаанбаатар хот

Монголын Банкны Холбоо (цаашид “МБХ” гэх)-ны гишүүн банкууд нь МБХ-ны дэргэдэх Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөлөөс боловсруулсан “Банкны даатгалын зуучлалын ажилтны ёс зүйн дүрэм” (цаашид “Ёс зүйн дүрэм” гэх)-ийг даатгалын зуучлалын үйл ажиллагаандаа нэгдсэн байдлаар, бүрэн хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэхээ баталгаажуулж, энэхүү баримт бичгийг үйлдэв.

Энэхүү Ёс зүйн дүрмийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-д үндэслэн боловсруулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1. Ёс зүйн дүрэмд тусгагдсан арга хэмжээнүүдийг МБХ-ны гишүүн банкуудын даатгалын нэгжийн удирдлага, ажилтан болон даатгалын зуучлалын эрх бүхий ажилтнууд МБХ-ны дэргэдэх Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөлийн төлөөллөөр дамжуулан хангаж ажиллана.

1.2. Ёс зүйн дүрэмд тусгагдсан арга хэмжээг МБХ-ны гишүүн бөгөөд даатгалын зуучлалын тусгай зөвшөөрөл эзэмшигч банк бүр зохих ёсоор, бодитой хэрэгжүүлж, суурь шалгуур, нөхцөлүүдийг нэг мөр хангаж ажиллана.

1.3. МБХ-ны гишүүн банкууд нь өөрийн байгууллагын ёс зүйн журам, дүрмээс хамааран энэхүү ёс зүйн дүрэмд зааснаас нэмэлт шаардлага тавих, заавар, журмыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлж болно.

1.4. “Банкны даатгалын зуучлалын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг энэхүү санамж бичгийн хавсралтаар батлав.

ХОЁР. БУСАД

2.1. Энэхүү санамж бичиг нь МБХ-ны гишүүн байгууллагуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурсныг МБХ-оос тэмдэг даран баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.2. Хавсралт нь энэхүү баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд баримт бичигт өөрчлөлт оруулах асуудлыг МБХ-ны дэргэдэх Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг үндэслэн МБХ-ны Гүйцэтгэх захирал бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга шийдвэрлэнэ.

2.3. Санамж бичиг болон “Банкны даатгалын зуучлалын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг МБХ өөрийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулна.

САНАМЖ БИЧГИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

**МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**


Л.АМАР УЛААНБААТАР ХОТ
ТН:1752 ☎ 8113785

**БОГД БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ**


П.САРУУЛ УЛААНБААТАР ХОТ
ТН:5903658

**КАПИТРОН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ**


Д.АРИУНАА
1115033100


**ТӨРИЙН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ**


Ө.ГАНТӨР

**УЛААНБААТАР ХОТЫН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**


А.ЭНХМЭНД


**АРИГ БАНКНЫ БҮРЭН ЭРХТ
ТӨЛӨӨЛӨГЧ**


Д.ГАНБАТ

**ГОЛОМТ БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ**


НОРИХИКО КАТО
GOLOMT BANK

**КРЕДИТ БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ**


Б.ЭРДЭНЭБАЯР

**ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**


М.ОТГОНБАЯР

**ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**


Ж.ЦЭЦЭНРАГЧАА
БАНК ХХН
ТТ:2588 ☎ 2693771

**ХААН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ОРЛОГЧ**

P. Mönkh
Р.МӨНХТУЯА



**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

O. Orkhon
О.ОРХОН



ХАСБАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

G. Tsevegjav
Г.ЦӨВӨГЖАВ



БАНКНЫ ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Банкны даатгалын зуучлалын ажилтны ёс зүйн дүрэм /"Дүрэм" гэх/-ийн зорилго нь банкны даатгалын зуучлал хариуцсан нэгжийн удирдлага, ажилтан болон даатгалын зуучлалын эрх бүхий ажилтны үйл ажиллагаандаа баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү Дүрэм нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Даатгалын зах зээлийн ёс зүйн журам болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Энэхүү Дүрэм нь даатгалын зуучлалын тусгай зөвшөөрөл авсан банк, түүний даатгалын нэгжийн удирдлага, ажилтан болон даатгалын зуучлалын эрх авсан ажилтнуудад хамаарна.

1.4. Даатгалын зуучлалын ажилтнууд нь өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, онцлогийг харгалзан энэхүү Дүрмийг баримталж ажиллана.

Хоёр. Даатгалын зуучлалын ажилтны баримтлах ёс зүйн тулгуур зарчим

2.1. Даатгалын зуучлалын ажилтан нь дараах мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

2.1.1. Хууль, шударга ёсыг дээдлэх;

2.1.2. Даатгуулагчийн нууцыг хадгалах;

2.1.3. Өөрийн үйлчилгээний талаар үнэн зөв, ил тод байх;

2.1.4. Даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.1.5. Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх;

2.1.6. Даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах;

2.1.7. Даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, дээшлүүлэх.

Гурав. Даатгалын зуучлалын ажилтны баримтлах ёс зүйн түгээмэл хэм хэмжээ

3.1. Даатгалын зуучлалын ажилтан нь хууль, шударга ёсыг дээдлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.1.1. Даатгалын тухай хууль тогтоомж, журам, дүрэм, зааврыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ үйлчилгээний болон харилцааны өндөр соёлтойгоор ажиллахыг эрхэмлэх;

3.1.2. Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан аливаа бодлого шийдвэрийн арга хэмжээнүүдийг олон нийтэд гуйвуулан хүргэхгүй байх;

3.1.3. Олон нийтэд зориулан гаргасан мэдээлэл, товхимол, зар сурталчилгаа болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь олон нийтийг төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулаагүй байх;

3.1.4. Аливаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;

3.1.5. Ажилтнууд нь өөрийн компани, түүний удирдлага болон төрийн эрх бүхий байгууллага, үйлчлүүлэгч, олон нийтийн хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл гаргахгүй байх;

3.1.6. Удирдлага болон ажилтнууд нь хувьдаа болон холбоотой этгээдэд ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх.

3.2. Даатгалын зуучлалын ажилтан нь даатгуулагчийн нууцыг хадгалах зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.2.1. Даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг Даатгалын тухай хуулийн 81.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 43.2 дахь хэсэг болон хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглаж, задруулахгүй байх.

3.3. Даатгалын зуучлалын ажилтан нь өөрийн үйлчилгээний талаар үнэн зөв, ил тод байх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.3.1. Үнэн зөв мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, даатгагчаа чөлөөтэй сонгох боломжийг харилцагчдад олгох;

3.3.2. Ажил төрлийн холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулах замаар аливаа шийдвэр гаргахад саад учруулахгүй байх;

3.3.3. Энэ журмын 3.1.3-т заасныг үл харгалзан олон нийтэд мэдээлэл тараасан бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, нэн даруй залруулах.

3.4. Даатгалын зуучлалын ажилтан нь даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.4.1. Даатгалын гэрээний стандарт, нөхцөлийг боловсруулахдаа талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харилцан хүндэтгэх;

3.4.2. Үйлчлүүлэгчтэй харилцахдаа хүнд суртал гаргах, аашилж зандрах, айлган сүрдүүлэх, дарамтлах, тэдгээрийн мэдлэг, мэдээллийн дутмаг байдлыг ашиглан хууран мэхлэх, нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүйгээр зайлсхийх зэрэг үйлдэл гаргахгүй байх;

3.4.3. Даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулахдаа тэдний эрх, үүргийн талаар тайлбарлаж, нөхөн төлбөр олгох болон олгохгүй байх нөхцөлийг мэдэгдэх, гэрээний ач холбогдлыг нь танилцуулах, хэрэв даатгалын тохиолдол гарсан талаар үйлчлүүлэгч хандсан бол зөвлөх, туслах зэргээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

3.4.4. Аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө даатгуулагч, түүнийг төлөөлж буй этгээдээс шан харамж авах, өгөх, шаардах зэргээр даатгалын салбарын нэр хүндийг унагах, шударга бус үйлдэл гаргахгүй байх.

3.5. Даатгалын зуучлалын ажилтан нь шударга өрсөлдөөнийг эрхэмлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.5.1. Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх бөгөөд өрсөлдөгчийн талаар нэр хүндийг нь гутаасан худал мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байж харилцан хүндэтгэлтэй хандах;

3.5.2. Даатгалын зуучлалын ажилтны эрх ашигт үл нийцэх үйл ажиллагаанд нэр төр, эрх мэдэл, албан тушаалаа ашиглан аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу тал олгох, хөнгөлөлт үзүүлэх, өөрийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглах, хуурамч бичиг баримт үйлдэхгүй байх;

3.5.3. Даатгалын хураамжийн хэмжээг үндэслэлгүйгээр бууруулах, нэмэхээс зайлсхийх.

3.6. Даатгалын зуучлалын ажилтан нь даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.6.1. Даатгалын зуучлалын зөвшөөрөл авсан банкууд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын ач холбогдлыг олон нийтэд таниулах, даатгуулагчдын даатгалын мэдлэгийг дээшлүүлэх, итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор санаачилгатайгаар хоорондоо хамтарч ажиллах, мэдээлэл солилцохыг эрмэлзэх;

3.6.2. Бусад даатгалын салбарын оролцогчдын талаар нэр хүндийг нь гутаасан худал мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байж харилцан хүндэтгэлтэй хандах.

3.7. Даатгалын зуучлалын ажилтан нь даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, дээшлүүлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.7.1. Мэргэжлийн болон ёс зүйн боловсролдоо анхаарч, мэргэшүүлэх сургалтад тогтмол хамрагддаг байх;

3.7.2. Өөрийн эзэмшсэн мэргэжил, мэдлэг, ур чадвар, дадлага туршлага дутагдалтай гэж үзвэл даатгалын үйлчилгээнээс сайн дураараа татгалзах;

3.7.3. Даатгалын салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, мэдээлэлтэй байнга танилцаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;

3.7.4. Өөрийн байгууллагыг төдийгүй даатгалын салбарыг төлөөлж байгаа гэдэг зарчмыг үйлчлүүлэгч болон бусад талуудтай харилцахдаа баримтлах.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү Дүрмийн хэм хэмжээг зөрчсөн байж болзошгүй талаар иргэд, байгууллагаас гомдол, мэдээлэл ирүүлсэн, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, шийдвэрлэнэ.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ
2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН 4-НИЙ ӨДӨР